



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

□ Хөдөлмөрийн дотоод журам, Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай □

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/346 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг тайлагнаж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Н.Нандин-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Н.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай.


4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА

Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/01
дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

д/д	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа				Хүрэх үр дүн	Хариуцагч
		2025	2026	2027	2028		
Зорилт 1. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн урамшуулал, тусламж, дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд							
1.1	Засгийн газрын баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож олгох;	+	+	+	+	Албан хаагчдын цалин хөлс, журмын дагуу нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	БХД НДГ
1.2	Төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын үр дүн, туршлагыг үндэслэн шатлан дэвшүүлэх;	+	+	+	+	Албан хаагчийн ур чадвар, мэргэшсэн байх, тогтвор суурьшилтай ажиллах боломж нэмэгдсэн байна.	
1.3	Албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, улсын байцаагчийн мэргэшлийн зэргийг шинээр болон ахиулан олгох, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдэл олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх;	+	+	+	+	Албан хаагчдын нэмэгдэл цалин хөлс, нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	
1.4	Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны нөхөх төлбөрийг НДЕГ-ын шийдвэрийн дагуу олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх;	+	+	+	+	Албан хаагчдын нэмэгдэл цалин хөлс нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	
1.5	Албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох мөн бусад хэлбэрээр урамшуулах боломжийг судлан төсөвт багтаан шийдвэрлэн олгох;	+	+	+	+	Албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, ажиллах урам нэмэгдсэн байна.	
1.6	Хууль тогтоомжид нийцүүлэн төрийн дээд одон медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах, сургалтад хамруулах, мэргэшил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр урамшуулах;	+	+	+	+	Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэн, ажиллах урам нэмэгдэж нийгмийн баталгаа хангагдсан байна.	

1.7	Албан хаагчдын ээлжийн амралт, нөхөх төлбөр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль бусад тогтоол, журам, шийдвэр, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх;	+	+	+	+	Албан хаагчдын цалин хөлс нэмэгдэж, нийгмийн баталгаагаар хангагдсан байна.	
1.8	Нийгмийн даатгалын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудын нийгмийн баталгааг “Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын дагуу ханган ажиллаж, дэмжлэг үзүүлэх;	+	+	+	+	Ахмад настнуудын амьдралын түвшин дээшилсэн байна.	
Зорилт 2. Ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл, бололцоог хангах зорилтын хүрээнд							
2.1	Ажлын байрны ажиллах орчны тохижилт, өрөө тасалгааны засвар үйлчилгээг сайжруулж, тавилга, техник хэрэгслэлээр хангах ажлыг шийдвэрлүүлэх;	+	+	+	+	Ажиллах орчин нөхцөл сайжирч, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	НДЕГ
2.2	Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах;	+	+	+	+	Тав тухтай, эрүүл аюулгүй ажиллах нөхцөл бүрдсэн байна.	
2.3	Албан хаагчдын нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг эерэг болгох;	+	+	+	+	Байгууллагын соёл, хамт олны уур амьсгал, ажил хийх урам зориг дээшилсэн байна.	
2.4	Эцэг эхийн зөвлөл гэх мэт хамт олны сонирхол, хөгжилд тулгуурласан албан бус бүлэг, багийн санаачилгыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	+	+	+	+	Хамтын ажиллагаа, багаар ажиллах чадвар, зөвлөлийн ажлын бүтээмж нэмэгдсэн байна.	БХД НДГ
2.5	Стресс менежмент болон харилцаа хандлага, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах;	+	+	+	+	Албан хаагчдын сэтгэл санаа тайван болж, ажиллах урам орсон байна.	
Зорилт 3. Амьдрах орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд							
3.1	Албан хаагчдын орон сууцны нөхцлөө сайжруулах зорилгоор зээл авах болон орон сууц худалдан авахад ипотекийн зээл авахад хамтран ажилладаг банктай холбон дэмжлэг үзүүлэх;	+	+	+	+	Амьдралын түвшин дээшилсэн байна.	
3.2	Шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд санхүүгийн болон бусад хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэх;	+	+	+	+	Сэтгэл зүй болон санхүүгийн байдал дээшилсэн байна.	БХД НДГ

3.3	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулагдаагүй буцалтгүй тусламж, нэг удаагийн тусламжийн зардлаас орон сууц, хашаа байшин худалдаж авахад дэмжлэг үзүүлэхийг удирдах дээд газарт уламжлан шийдвэрлүүлэх;	+	+	+	+	Амьдралын түвшин дээшилсэн байна.	НДЕГ
Зорилт 4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилтын хүрээнд							
4.1	Жил бүр эрүүл мэндийн урьдчилэн сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ оношлогоонд хамруулах арга хэмжээ авч, энэ талаар зохих эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;	+	+	+	+	Эрүүл байх, эрүүл амьдрах хэв маяг, дадал зуршилтай болсон байна.	БХД НДГ
4.2	Дархлаажуулалтыг сайжруулах, витаминжуулах ажлыг жилд 1 удаа зохион байгуулах;	+	+	+	+	Албан хаагчдын биеийн дархлаа сайжирч, эрүүл амьдрах зөв дадал, хандлагатай болсон байна.	
4.3	Байгууллага, хамт олноороо аливаа хорт зуршлаас татгалзан, амьдралын зөв хэвшил, дадал, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, санал санаачилгыг дэмжих, түгээх, өрнүүлэх;	+	+	+	+	Хамт олонч сэтгэлгээ, багаар ажиллах дадал, зөв амьдралын хэв шинжтэй болсон байна.	
4.4	Салбарын болон дүүргийн хэмжээнд зохион байгуулагдаж буй спорт, нийтийн биеийн тамирын хөтөлбөр, соёл урлагийн арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй оролцох;	+	+	+	+	Албан хаагчдын чөлөөт цагаараа зөв боловсон амарч, өнгөрөөх таатай нөхцөл бүрдсэн байна.	
4.5	Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд 1 удаа идэвхтэй амралт, аялал зохион байгуулах;	+	+	+	+	Хамт олны уур амьсагал дээшилсэн байна.	
4.6	Жирэмсэн амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй болон бусад шалтгаанаар түр чөлөөтэй албан хаагчдыг хамт олны аливаа арга хэмжээнд татан оролцуулах, хамруулахад санаачилгатай ажиллах;	+	+	+	+	Албан хаагчдын уур амьсгал өөрчлөгдсөн байна.	
4.7	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон хөгжлийн талаарх соёлын арга хэмжээг дэмжиж ажиллах;	+	+	+	+	Эко амьдралын дадалтай болж, албан хаагчдын уур амьсгал өөрчлөгдсөн байна.	
4.8	Байгууллага хамт олноороо нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажилд оролцож					Бусдад хандах хандлага эерэгээр өөрчлөгдсөн байна.	

	дэмжиж ажиллах;						
Зорилт 5. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд							
5.1	Удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хоорондын харилцаа, хандлагын хэв маягийг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх;	+	+	+	+	Албан хаагчдын харилцаа, хандлага сайжирсан байна.	БХД НДГ
5.2	Албан хаагчдын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах;	+	+	+	+	Албан хаагчдын ажлын ачаалал, ажил үүргийн давхардал арилсан байна.	БХД НДГ
Зорилт 6. Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамруулах зорилтын хүрээнд							
6.1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/296 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын сургалтын хөтөлбөр”-ийн дагуу албан хаагчдыг тасралтгүй сургах мэргэшүүлэх;	+	+	+	+	Албан хаагчдын мэдлэг, мэргэшил дээшилсэн байна.	БХД НДГ